



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

“ТОСК түрээс нэг” ХХК-д тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 12 дугаар зүйлийн 12.4, 12.5 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасан “санхүүгийн бусад байгууллага” гэдэгт “ТОСК” ТӨҮГ-г тооцож, “ТОСК түрээс нэг” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгосонтой холбоотойгоор баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагааны бэлтгэлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн хангахыг “ТОСК түрээс нэг” ХХК /Д.Оюунжаргал/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрөл болон оноосон нэрэнд өөрчлөлт оруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 10 хоногийн дотор эргэн мэдэгдэхийг “ТОСК түрээс нэг” ХХК-д үүрэг болгосугай.

4. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/- т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000005